



Нэгдүгээр хэсэг. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 50 сонгох даалгавартай нийт 76 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье**

- Газарзүйн зургийг ажиглан ЗУ96⁰-ийн шугамыг дайран өнгөрч буй аймгуудыг сонгоно уу? /1 оноо/




- Завхан, Говь-Алтай В. Хэнтий, Завхан С. Говь-Алтай, Ховд
 - Дорнод, Хэнтий Е. Архангай, Хөвсгөл
- Гималайн нуруу тектоникийн хавтангуудын ямар хөдөлгөөний үр дүнд үүссэн бэ? Зургийг ажиглан хариултыг сонгоорой. /1 оноо/



- Еврази - Хойд америк, шилжин зөрөх
- Энэтхэг Австрали-Африк ойртон нийлэх
- Африк – Өмнөд Америк, холдон салах
- Еврази - Номхон далай, шилжин зөрөх
- Энэтхэг Австрали-Еврази, ойртон нийлэх



3. Дараах үзүүлэлтүүдийн аль нь хөгжиж буй орны шинж вэ? /1 оноо/
 А. Шинээр аж үйлдвэржиж буй В. Нийгмийн дундаж давхаргын эзлэх хувь их
 С. Үйлчилгээний салбар эрчимтэй хөгжсөн D. Хүн амын өсөлт бага
 Е. Шинжлэх ухаан, технологийн ололт өндөр
4. Солонгосын к-поп, к-драм дуу хөгжим, кино урлаг дэлхий даяар түгэн тархжээ. Энэ нь даяаршлын ямар хэлбэрт орох вэ? /1 оноо/
 А. Нийгмийн даяаршил В. Эдийн засгийн даяаршил С. Соёлын даяаршил
 D. Ардчиллын даяаршил Е. Улс төрийн даяаршил
5. Аж үйлдвэрийн салбаруудыг анхдагч, хоёрдогч, гуравдагч, дөрөвдөгч гэсэн хэв шинжүүдэд ангилдаг. Гуравдагч аж үйлдвэрийн хэв шинжид хамаарахыг нь сонгоно уу /1 оноо/
 А. Судалгаа шинжилгээ В. Боловсруулах үйлдвэр С. Хөдөө аж ахуй
 D. Үйлчилгээний салбарууд Е. Харилцаа холбоо
6. Дулаан ба чийгийн хувьд улирлын ялгаа байхгүй, жилийн дундаж температур 20°C-аас дээш байдаг бүслүүр аль нь вэ? /1 оноо/
 А. Дулаан бүслүүр В. Экваторын бүслүүр С. Халуун бүслүүр
 D. Хүйтэн бүслүүр Е. Сэрүүн бүслүүр
7. Монгол улс 150 тэрбум гаруй тн нүүрсний нөөцтэй, 300 гаруй орд илэрцтэй. Багануурын нүүрсний орд нь дунд төрмөлийн аль галавт үүссэн бэ? /1 оноо/
 А. Юра В. Карбон С. Цэрд D. Перм Е. Триас
8. Янз бүрийн гадаргын ойлгох чадвар өөр өөр байдаг. Дараах өгөгдлүүдээс хамгийн өндөр альбедотойг нь сонгоно уу /1 оноо/
 А. Цөл В. Элс С. Ой мод D. Хар зам Е. Зузаан үүл
9. Тухайн температур бүхий агаарын үнэмлэхүй чийгийн хэмжээг үнэмлэхүй чийгийн багтаамжид харьцуулж хувиар илэрхийлснийг юу гэж нэрлэх вэ? /1 оноо/
 А. Дутмаг чийг В. Үнэмлэхүй чийгийн багтаамж С. Шүүдэр цэг
 D. Харьцангуй чийг Е. Үнэмлэхүй чийг
10. Голын эх ба адгийн өндрийн зөрүүг юу гэдэг вэ? /1 оноо/
 А. Голын хэвгий В. Голын унал С. Голын хөндлөн зүсэлт
 D. Голын дундаж гүн Е. Голын сүлжээний нягтшил
11. Зурагт 10-ийн тоогоор тэмдэглэсэн урсгалыг нэрлэнэ үү? /1 оноо/



- А. Перугийн урсгал В. Гольфстримийн урсгал С. Баруун зүгийн салхины урсгал
 D. Бразилийн урсгал Е. Канарын урсгал



12. Хөрсний доройтол, элэгдэлд нөлөөлөх НИЙГМИЙН хүчин зүйлийг сонгоно уу.


/1 оноо/

- A. Шар усны үерт автах
B. Тогтмол салхины нөлөө ихсэх
C. Усалгаатай талбай нэмэгдэх
D. Хөрсний гулсалтад өртөх
E. Эрдсийн хэмжээ буурах

13. Оросын Холбооны улс 143.000.000 хүн амтай, газар нутгийн хэмжээ 17.023.000 км² бол хүн амын нягтшил хэд байх вэ? /1 оноо/

- A. 1км²-т 5.4 хүн ноогдоно
B. 1км²-т 6.4 хүн ноогдоно
C. 1км²-т 4.4 хүн ноогдоно
D. 1км²-т 8.4 хүн ноогдоно
E. 1км²-т 7.4 хүн ноогдоно

14. Зургийг ажиглан растерийн оновчтой дүрслэлийг сонгоно уу. /1 оноо/



A.

B.

C.

D.

E.

15. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Газарзүйн мэдээллийн систем нь компьютерт суурилсан буюу тоон.....орон зайн өгөгдлийг ашиглан газарзүйн зураг, газарзүйн мэдээллийн загварчлалыг боловсруулдаг технологийн шийдэл юм./1 оноо/

- A. технологи B. байршил C. өгөгдөл D. тандалт E. зураглал

16. Дараах улсуудыг орших газартай нь зөв харгалзуулна уу /1 оноо/

Орших газар	Орших улсууд
1. Арал	а. Казакстан
2. Хойг	б. Сауд Араб
3. Эх газар	в. Шинэ Зеланд


- A. 1в, 2б, 3а B. 1б, 2в, 3а C. 1в, 2а, 3б D. 1б, 2а, 3в E. 1а, 2в, 3б

17. Даяаршлын СӨРӨГ талыг дурдсан хариултыг сонгоорой. /1 оноо/

- A. Төвлөрлийг сааруулах
B. Шинэ санаа, мэдээлэл солилцох
C. Улс дамнан зайнаас ажил хийх
D. Цөөхөн улс орон улам хүчирхэгжих
E. Технологийн ололт амжилт нэвтрэх



18. Зургийн агуулга юуг илэрхийлж байгааг хариултаас сонгоно уу /1 оноо/



- A. Байгалийн нөхцөл
D. Хүн амын өсөлт
- B. Аж үйлдвэржилт
E. Байгалийн нөөц
- C. Соёлын ялгаа

19. Жуулчдын аюулгүй байдлыг хангаж эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ямар үйлчилгээг сонгож авах вэ? /1 оноо/

- A. Ахуйн үйлчилгээ
D. Боловсролын үйлчилгээ
- B. Соёлын үйлчилгээ
E. Даатгалын үйлчилгээ
- C. Урлагийн үйлчилгээ

20. Эх дэлхийдээ ээлтэй ногоон амьдралын хэв маягт тохирсон дахин ашиглагдах бүтээгдэхүүнийг сонгоно уу /1 оноо/

- A. Нэг удаагийн аяга
D. Цэцгийн баглаа
- B. Даавуун тор
E. Гялгар уут
- C. Лаазалсан хүнс

21. Дараах хариултаас дотоод цөмийг зөв тодорхойлсныг нь сонгоорой. /1 оноо/

- A. Нягт бага, сийрэгжсэн, уян налархай шинжтэй.
B. Нягт их, 900-2900 км-ыг хооронд тархана.
C. 2900-5150 км-ыг хооронд тархаж, долгионы хурд удааширна.
D. Даралт хамгийн өндөр, хатуу бодисоос тогтоно.
E. Нягт багатай, тунамал, боржин, хүрмэн чулуун үе давхаргатай.

22. Тунамал чулуулаг аль нь болохыг сонгоорой. /1 оноо/

- A. Элс
B. Боржин
C. Гантиг
D. Кварцит
E. Габбро

23. Газарзүйн зурагт Миссиппи мөрний байршлыг тодруулан харуулжээ. Хаанаас эх авч, хаана цутгаж байгааг сонгоно уу /1 оноо/

- A. Андын нуруунаас эх авч Атлантын далайд цутгана.
B. Гималайн нуруунаас эх авч Энэтхэгийн далайд цутгана.
C. Андын нуруунаас эх авч Номхон далайд цутгана.
D. Дорнод африкийн уулсаас эх авч Газар дундад тэнгист цутгана.
E. Кордильерын нуруунаас эх авч Атлантын далайд цутгана.






24. Зургийг ажиглан биомандлын хамрах хүрээг тодорхойлсон хариултыг сонгоно уу /1оноо/



- А. Усан мандал хамаарна.
- В. Чулуун ба усан мандал хамаарна.
- С. Агаар мандал хамаарна.
- Д. Дэлхийн бүх мандал хамаарна.
- Е. Чулуун ба агаар мандал хамаарна.


25. 1800 оны эхэн хүртэл дэлхийн хүн амын тоо 1 тэрбумд хүрдэггүй байв. Графикийг ажиглан хэдэн оны хооронд хүн амын өсөлт хамгийн бага байгааг сонгоно уу /2 оноо/



- А. 1900-1950
- В. 1700-1750
- С. 1850-1900
- Д. 1800-1850
- Е. 1750-1800



26. Хүн амын суваргыг ажиглан хэдэн насны шатлал дахь ямар хүйсийн хүмүүсийн эзлэх хувь их болохыг тодорхойлоорой. /2 оноо/




- A. 25-29 насны, эмэгтэй
 B. 35-39 насны, эрэгтэй
 C. 30-34 насны, эрэгтэй
 D. 25-29 насны, эрэгтэй
 E. 35-39 насны, эмэгтэй

27. Цэгийн оронд тохирох үгийг нөхөөрэй. Саудын Араб улсаас Япон улс руу жилд дунджаар 600 сая орчим тнтээвэрлэдэг. Үүний дийлэнх ньтээврийн төрлийг ашигладаг байна. /2 оноо/

- A. зэсийг, цахилгаан
 B. байгалийн хийг, хоолойн
 C. нүүрсийг, авто замын
 D. алтыг, дамжуулах хоолойн
 E. газрын тосыг, усан замын


28. Газар хөдлөлтийн хүч, хугацаа давтамжийг сейсмографийн тусламжтайгаар тогтоож болдог. Зургийг ажиглан хамгийн хүчтэй чичирхийлэл нь хэд дэх секундэд болсон байгааг тодорхойлно уу. /2 оноо/



- A. 0.2, 15 дахь секундэд
 B. 0.2, 5 дахь секундэд
 C. 0.1, 20 дахь секундэд
 D. 0.3, 10 дахь секундэд
 E. 0.3, 5 дахь секундэд



29. Зургийг ажиглан стратосфер /давхраат мандал/-ийн давхаргыг зөв тодорхойлсон хариултыг сонгоорой. /2 оноо/



- A. Температур буурч, салхины хурд 150м/сек хүрнэ
- B. Цаг агаарын бүх үзэгдэл явагддаг.
- C. Температур нэмэгдэж 1500°C хүрнэ.
- D. Үүлгүй. Озоны давхарга оршино.
- E. Ионжилт их, устөрөгч илүү зонхилно.


30. 2005 оны 8 сарын Катрина хар салхины үеэр 1836 хүн амь насаа алдан, 108 тэрбум ам/долларын хохирол учирчээ. Хар салхины үргэлжилсэн өдрүүд болон даралтыг зургаас ажиглан салхины хүч хамгийн их байсан өдрүүдийг сонгоно уу. /2 оноо/



- A. 29-30-ны өдрүүд
- B. 24-25-ны өдрүүд
- C. 25-26-ны өдрүүд
- D. 30-31-ны өдрүүд
- E. 26-27-ны өдрүүд



31. Завхан аймгаас Оросын Холбооны улс руу явахад хамгийн ойрын, байнгын ажиллагаатай боомт аль нь вэ? /2 оноо/



- А. ЗамынҮүд-Эрээн
В. Алтанбулаг-Хиагт
С. Бичигт-Зүүнхатавч
D. Боршоо-Хандгайт
E. Гашуунсухайт-Ганц мод

32. Google earth программын зурагт 3-ын тоогоор тэмдэглэсэн командыг идэвхжүүлээд цаг агаарын ямар элементийг харж болох вэ? /2 оноо/



- А. Температур
В. Салхи
С. Хур тунадас
D. Даралт
E. Үүлшилт

33. Доорх зургийг ашиглан Дэлхий ба Бархасбадь гаригуудын хоорондын зайг одон орны нэгжээр /о.о.н/ илэрхийлээрэй./1 о.о.н=Нар дэлхийн хоёрын хоорондох зай/ /2 оноо/



- А. 8.18 о.о.н
В. 5.18 о.о.н
С. 6.18 о.о.н
D. 7.18 о.о.н
E. 4.18 о.о.н



34. Жилийн хоногийн тоо нь 4 жилд нэг удаа 366 хоног болох үеийг юу гэж нэрлэдэг вэ? /2 оноо/

A. Сарны фаз B. Илүү сар C. Өндөр жил D. Аргийн тоолол E. Билгийн тоолол

35. Зургийг ажиглан 8 ба 6-ийн тоогоор тэмдэглэгдсэн хаант засаглалтай Европ тивийн улсыг сонгоно уу. /2 оноо/



A. Тайланд, Бруней
D. Испани, Непал

B. Их Британи, Япон
E. Ватикан, Япон

C. Норвег, Испани

36. Хүн амын ихэнх нь испани хэлтэй, католик шашинтай, хөлбөмбөг тоглож, салса, румба, бүжиглэдэг. Энэ бүс нутаг соёлын газарзүйн тархалтын ямар мужид хамаарах вэ? /2 оноо/

A. Латин америкийн
D. Словян ба оросын

B. Хойд америкийн
E. Зүүн өмнөд азийн

C. Араб исламын

37. Дараах хотуудаас ЕВРОП тивийн бета хотыг сонгоорой. /2 оноо/

A. Хонконг B. Бостон C. Осака D. Лос-Анжелес E. Мадрид


38. Малчин А-ынх 10 үхэр, 5 адуу, 30 ямаа, 45 хонь нийт 90 толгой малтай ба бэлчээрийн даацын хуваарилалт хийхийн тулд бүх сүргийг хонин толгойд шилжүүлэн тооцоолно уу. /1 үхэр=6 хонь, 1 адуу=6 хонь, 1 ямаа=0.9 хонь, 1 хонь=1 хонь/ /2 оноо/

A. 182 хонин толгой
B. 132 хонин толгой
C. 192 хонин толгой
D. 102 хонин толгой
E. 162 хонин толгой

Бодолт:



39. Графикийг ажиглан интернетээр мэдээлэл авах хэрэгцээг хангах шаардлагатай орнуудыг сонгоно уу. (Worldwide Statista, 2020) /2 оноо/



- А. Япон, Хятад
В. Канад, Аргентин
С. Португал, Непал
D. Узбекистан, Киргизстан
E. Герман, Турк

40. Жуулчид Хөвсгөл нуур орчмын аялалд гарахаар болжээ. Рекреацийн ямар нөөцөд тулгуурласан аялал болох вэ? /2 оноо/

- А. Шашны сүм хийд, эртний барилга байгууламж
В. Түүхэн хөшөө дурсгал, хиргисүүр, гэрэлт хөшөө
С. Хүний гараар бүтээгдсэн сүм хийд, музей
D. Цэнгэг уст нуур, цаатангуудын аж амьдрал
E. Говийн манхан, рашаан сувиллын газар


41. Тухайн бүсийн онцлогийг зөв тодорхойлсныг нь сонгоно уу. /2 оноо/



- А. Баруун Европ-хотжилт, машин үйлдвэрлэл
В. Баруун өмнөд Ази - Газрын тосны олборлолт
С. Зүүн өмнөд Ази-Тээвэр, шинэ аж үйлдвэржилт
D. Зүүн Ази-Технологи, электроник
E. Төв Америк -Хөдөө аж ахуй газар тариалан



42. Графикийг ажиглаарай. 3-р сард салхины хурд өмнөх оны мөн сараас хэдэн м/сек-ээр нэмэгдсэн байна вэ? /2 оноо/



- A. 1.0 м/сек
B. 1.5 м/сек
C. 2.0 м/сек
D. 0.5 м/сек
E. 2.5 м/сек


43. Австралийн эх газрын гадаргын байдлыг зөв тодорхойлсон хариултыг сонгоорой.
/2 оноо/



- A. Өмнөд талаараа уулархаг, нуурууд ихтэй.
B. Баруун талаараа өндөрлөг, гадаргын ус ихтэй
C. Зүүн талаараа талархаг, нуурын тархалт ихтэй
D. Төв хэсгээрээ гадаргын ус их, өндөр уулстай
E. Зүүн талаараа уулархаг, баруун хойд талаараа цөлөрхөг



44. Тасалгааны температур $+20^{\circ}\text{C}$ байв. Үнэмлэхүй чийгийн хэмжээ 14г/м^3 бол харьцангуй чийгийн хэмжээ хэд байгааг тооцоолно уу? /агаарын температур $+20^{\circ}\text{C}$ байх үед чийгийн багтаамж 17.32 г/м^3 байна/ **/2 оноо/**
 A. 80.8% B. 19.7% C. 18.3% D. 30.3% E. 66.9%
45. Гамби улс дотоодын усны хэрэглээнийхээ 94%-ийг импортоор авдаг. Үүнд нөлөөлсөн байгалийн хүчин зүйлийг сонгоорой. **/2 оноо/**
 A. Дотоодын мөргөлдөөн зөрчил их B. Хүн амын усны хэрэглээ өндөр
 C. Хөвөнгийн тариалалтад ус их хэрэглэнэ D. Далайн хүйтэн урсгалын нөлөө
 E. Усны зохисгүй хэрэглээтэй
46. Дэд бүтцийн салбарт хөрсний үзүүлэх үүрэг аль нь вэ? **/2 оноо/**
 A. Организмуудын амьдрах орчин болдог
 B. Нүүрстөрөгч шингээгч болдог
 C. Барилга, зам гүүрийг төлөвлөхөд чухал үүрэгтэй.
 D. Уур амьсгалыг хуурайшуулахад чухал үүрэгтэй.
 E. Түүх соёлын өв тээгч болдог
47. Google earth-ийн зургийг ажиглан Явуухулангийн цэцэрлэг Улсын их дэлгүүрээс аль зүгт байгааг тодорхойлоорой. **/2 оноо/**



- A. Зүүн хойд B. Зүүн урд C. Баруун урд D. Зүүн E. Хойд
48. Тус улс нь 2.000.000 хүн амтай, хүн амын ердийн өсөлт нь 2% бол хэдээр нэмэгдсэнийг тооцоолоорой. **/2 оноо/**
 A. 40000
 B. 4000
 C. 20000
 D. 2000
 E. 10000

Бодолт:



49. Лондон хотын агаарын температур $+72^{\circ}\text{F}$, Бусан хотын агаарын температур $+18^{\circ}\text{C}$ байв. Хоёр хотын агаарын температурын зөрүү франгейтын хуваариар хэд болохыг тооцоолоорой. /2 оноо/ $9/5^{\circ}\text{C}+32=^{\circ}\text{F}$
 A. 64.4°F B. 7.6°F C. 15.2°F D. 54.4°F E. 10.6°F

50. Хүснэгтэн мэдээллийг ашиглан Монгол улсын хөдөө аж ахуйн усны хэрэглээг дэлхийн дундажтай харьцуулан, шалтгааныг тодорхойлж тооцоолол хийнэ үү.
 /2 оноо/

№	Салбар	Дэлхийн дундаж /%/	Монгол улсын дундаж /%/
1	Хөдөө аж ахуй	67	28
2	Хүн амын унд, ахуй	9	16
3	Эрчим хүч	7	25
4	Үйлдвэрлэл	11	8
5	Уул уурхай	2	22
6	Бусад	4	1
Нийт		100	100


- A. Ус түгээх шугам сүлжээний засвар үйлчилгээ муу, 39%-иар их
 B. Хотод амьдрах иргэдийн тоо дэлхийн дунджаас их, 20%-иар их
 C. Орон сууцанд амьдрах иргэдийн тоо их, дунджаас 20%-иар бага
 D. Гэр хороололд амьдрах иргэдийн тоо их, дунджаас 3%-иар их
 E. Хөдөө аж ахуй нь эрчимжиж байгаа, дунджаас 39%-иар бага



Хоёрдугаар хэсэг. НӨХӨХ ДААЛГАВАР

Санамж: Даалгавруудын хариултыг бөглөхдөө хариултын хуудасны 2-р хэсгийг бөглөх заавартай сайтар танилцаарай. Зургийг бодит хэмжээгээр өгөөгүй гэдгийг санаарай.

2.1 Зургийг ажиглан дэлхийн хөдөлгөөний даалгавруудыг гүйцэтгээрэй. /6 оноо/



- I. Дэлхий 1-ын тоогоор тэмдэглэгдсэн байршилд байх үед, хойд хагаст улирал болон нарнаас алслагдсан зай ямар байхыг тодорхойлно уу /a/ /2 оноо/

1. Өвөл, 147 сая км 2. Намар, 150 сая км 3. Хавар, 150 сая км
4. Зун, 152 сая км 5. Жилийн турш, 150 сая км

- II. 2-ийн тоогоор тэмдэгдсэн байрлал буюу 3 сарын 21нд ХӨ38⁰ тусах нарны өндрийг тооцоолно уу /bc/ /2 оноо/ $H=90-\varphi$

[illegible]

- ### III. Өгүүлбэрийг нөхөөрэй.


Дэлхий.....нэг бүтэн тойрох хугацааг.....гэдэг. /d/ /2 оноо/

1. нарыг, жил 2. тэнхлэгээ, сар 3. сарыг, хоног
4. тэнхлэгээ, жил 5. нарыг, хоног




2.2 Монгол улсын 2023-2024 оны нислэгийн мэдээллийг ашиглан даалгавруудыг гүйцэтгээрэй. /6 оноо/

I. Улаанбаатараас хамгийн олон хүн зорчсон альфа зэрэглэлийн хот аль нь вэ? /a/
/2 оноо/



1. Бээжин 2. Токио 3. Сөүл 4. Истанбул 5. Фукуока

II. Олон улсын нислэгийн тоон графикийг ашиглан зорчигч өмнөх оноос хэдэн хувиар өссөнийг тооцоолоорой **/bc.d/** **/2 оноо/**


[illegible]

III. Автобус 120 км-ын зайтай хоёр хотын хооронд 28 хүн тээвэрлэсэн бол зорчигч эргэлтийг олоорой. /efgh/ /2 оноо/

[illegible]

2.3 Гадаргыг өөрчилдөг эндоген ба экзоген хүчин зүйлстэй холбогдох даалгавруудыг гүйцэтгээрэй /6 оноо/

I. Зургийг ажиглан Евразийн хавтанд хамаарагдах газар нутгийг нь сонгоно уу /a/ /1 оноо/



1. Атлантын далай, Японы арал
2. Атлантын далай Мадагаскар арал
3. Атлантын далай Гренланд арал
4. Энэтхэгийн далай, Тасман арал
5. Карибын тэнгис, Панамын суваг

II. Эндоген ба экзоген үйл явцуудыг зөв харгалзуулна уу. /5 оноо/ [b][c][d][e][f]

B	Номхон далайн хавтангийн хил заагаар орших галт уул, газар хөдлөлтийн бүсүүд	1	Антиклинал
C	Чулуулгийн ан цавд ус хөлдөж тэлснээс үүсэх өгөршил	2	Органик өгөршил
D	Амьтан ургамал элдэв бактерийн үйл явцад чулуулаг задарч бутрах өөрчлөгдөх	3	Галт цагираг
E	Дээд мантийн дээд үед орших халуун хайлмал гулгамтгай үе	4	Хүйтний өгөршил
F	Гадаргын атирааны гүдгэр хэлбэр	5	Астеносфер

2.4 Хүснэгтэн мэдээллийг ашиглан дараах даалгавруудыг гүйцэтгээрэй. /6 оноо/

№	Далайн үзүүлэлтүүд	А. Номхон далай	Б. Атлантын далай	В. Хойд мөсөн далай	Г. Энэтхэгийн далай	Д. Өмнөд далай
1	Талбай /сая.км2/	165.2	92.4	14.0	73.5	15.9
2	Дундаж гүн /м/	4280	3646	1038	3741	4500
3	Температур /°C/	28.3	21.5	-1.2	25.2	2.5
4	Давсжилт /‰/	34.1	33.2	32.1	34.5	34.2

I. Газарзүйн зураг дээр ижил гүнтэй цэгүүдийг холбон зурсан шугамыг юу гэж нэрлэдэг вэ? /a/ /1 оноо/

1. Изобар
2. Изобат
3. Изотерм
4. Изогипс
5. Изотахи

II. Номхон далай ба Энэтхэгийн далайн температурын дундажийг тооцоолоорой. /bc.d/ /2 оноо/

III. Далайн талбайнуудын тоон утгыг ихээс бага руу нь эрэмбэлээрэй. /e/ /3 оноо/

1. А-Б-Г-Д-В
2. Б-А-Г-Д-В
3. Д-Б-Г-А-В
4. Г-Б-А-Д-В
5. В-Б-Г-Д-А

